



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 156

Сүхбаатар сум

Г “Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалыг
хөгжүүлэх хөтөлбөр” батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь заалт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр бүлгийн 1.2.13 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, хөтөлбөрийн биелэлтийн явцыг 2 жил тутамд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /Ш.Оргил/-д даалгасугай.

ДАРГА
Г БЯМБАА

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн
156 дугаар тогтоолын хавсралт

СЭЛЭНГЭ АЙМГИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

446 9055363

Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын өнөөгийн байдал

Сэлэнгэ аймагт Монгол Улсын ойн сангийн 8 орчим хувь, урсгал усны 40 хувь, Улсын болон орон нутгийн чанартай 936,5 км авто зам болон Сэлэнгэ аймгийн 7 сумын нутгаар Монгол-ОХУ хамтарсан Улаанбаатар төмөр зам дайран өнгөрдөг. Аймгийн нутаг дэвсгэрийн 10 орчим хувийг улсын болон аймаг, орон нутгийн чанартай Тусгай хамгаалалттай газар нутаг эзэлдэг. Аймгийн хэмжээнд байгалийн үзэсгэлэнт газар 43, түүх, соёлын дурсгалт газар 84, эмчилгээ сувилгаа, рашаан ус, эмийн ховор ургамалтай 11 газар байгааг тодорхойлсон.

Сэлэнгэ аймаг нь ОХУ-тай хил залгаа Алтанбулаг боомттой, дэд бүтцийн хөгжил сайтай, түүхийн дурсгалт газар болон үзэсгэлэнт байгальтай аялал жуулчлалыг хөгжүүлэхэд бүрэн боломжтой бүс нутаг. Монгол Улсын иргэд ОХУ-д визгүй зорчилоос гадна Алтанбулаг-Хиагтын боомт нь хорин дөрвөн цагийн үйл ажиллагаатай болсон зэрэг нь хилээр дамжин өнгөрөх болсноор дотоод, гадаадын жуулчид, иргэдийн тоо эрэс нэмэгдсэн. 2016 оны жилийн эцсийн байдлаар хилийн боомтоор 1,3 сая иргэн хил нэвтэрснээс Монгол зорчигчдын тоо 2015 оныхаас 40,78 хувиар/1178133 зорчигч/, гадаадын зорчигчдын тоо 29,8 хувиар /152829 зорчигч/ тус тус өссөн.

Сэлэнгэ аймаг нь зорин ирэх жуулчлалаар гадна ОХУ-аар дамжуулан гуравдагч орны жуулчдыг Монголд аялуулах, дамжин өнгөрүүлэх нөхцлийг бүрдүүлдгээрээ онцлогтой. Аймгийн хэмжээнд аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлдэг 23 жуулчны бааз, гэр буудал, амралтын газар, 34 зочид буудал, дэн буудал жуулчдыг хүлээн авч, үйлчилж байна. Эдгээр жуулчны бааз, зочид буудал, үйлчилгээний байгууллагууд нь жилийн турш 360 орчим түр болон байнгын ажлын байрыг бий болгож байна.

Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах үндэслэл

Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутаг дахь “Амарбаясгалан” хийд, Ерөө сумын нутаг дахь “Халуун рашаан”, Ардын Хувьсгалын өлгий нутаг Алтанбулаг сумын нутаг дахь “Гүн нуур”, “Хонд”, “Буур хээрийн тал”, “Хоёр элс”, Алтанбулаг хилийн боомт, аймгийн “Нэгдсэн музей”, “Сайхны хөтөл”, Сүхбаатар сумын нутаг дахь “Ээж мод”, Хүдэр сумын нутаг дахь “Соронзон хад”, “Хүн чулууны бичээс”, Цагааннуур сумын нутаг дахь “Номун хаан хийдийн туурь” зэрэг байгалийн өвөрмөц, содон тогтоц, уламжлалт ёс заншил, түүх дурсгалын өлгий нутаг, түүх дурсгалт газар, дэд бүтэц зэрэг давуу тал байгаа нь аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тохиромжтой бүс нутаг болдог.

Түүнчлэн Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын нүүр царай, өнгө төрх болсон байгалийн үзэсгэлэнт болон түүх соёлын дурсгал, уламжлалт зан үйлтэй холбоо бүхий эдгээр газар орныг нөхөн сэргээх, тохижуулах, ашиглах хамгаалах менежментийг сайжруулахад төрийн байгууллагууд болон хувийн хэвшил, төрийн бус байгууллага, орон нутгийн иргэдийн хамтын оролцоо чухал байна.

Сүүлийн жилүүдэд өсөн нэмэгдэж байгаа дотоодын жуулчдын урсгал хөдөлгөөнийг дагаад аялал, жуулчлалын үйл ажиллагаанд өртөгдөж байгаа бус нутгуудад орчны доройтол, авто замын эвдрэл, хог хаягдлын асуудлууд хөндөгдөж байна.

Түүнчлэн хол зам туулан зорьж ирсэн гадаад, дотоодын жуулчдын аюулгүй байдлыг хангах, ая тухтай аялах боломжийг бүрдүүлэх, сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл хэлбэрийг бий болгоход анхаарч, аймаг, орон нутгийн онцлогийг тусгасан бэлэг дурсгалын зүйлс, нутгийн онцлог бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, сав баглаа боодол, өнгө үзэмжийг сайжруулах, төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг борлуулах зах зээлийг өргөжүүлэх нь нэн тэргүүний зорилт болж байна.

Аялал жуулчлал гэдэг нь маш өргөн хүрээтэй олон салбарын уялдаа холбоо нэгдэл дээр тулгуурладаг салбар тул аймаг, орон нутгийн онцлог, жуулчдын урсгал хөдөлгөөн, дэд бүтэц, гадаад харилцааны чиг хандлагатай нийцүүлэн салбар хоорондын уялдаа холбоог хангах асуудлуудыг ч бас хөндсөн болно.

Сэлэнгэ аймгийн давуу тал, нөөц боломжкоо бүрэн ашиглаж нэгдсэн бодлоготойгоор гадаад, дотоодын аялагч, жуулчдыг татах, хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх, ая тухтай нөхцлийг бүрдүүлэх, орон нутаг, ёс заншлаа сурталчлах, таниулах зэргээр аялал, жуулчлал, эдийн засгийн таатай бус нутаг болохын тулд үндэсний хөтөлбөр, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийцүүлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөрөө шинэчлэн баталж, мөрдөж ажиллах шаардлагатай байна.

Аялал жуулчлал хөгжүүлэх давуу талууд:

1.Газар нутгийн хувьд

- Олон голын сав газар-усан орчин /Орхон Сэлэнгийн бэлчир, Сайханы Хөтөл, Зэлтэр, Хүдэр, Хонин нуга зэрэг байгалийн хосгүй үзэсгэлэнт газрууд/
- Тужийн нарсны байгалийн цогцолборт хамгаалалтын газар, Хан-Хэнтийн дархан цаазат газартай
- Ардын хувьсгалын болон түүхийн дурсгалт газрууд

2.Байгалийн нөөцийн хувьд

- Байгалийн өвөрмөц тогтоц бүхий газруудтай
- Газар тариалан эрхлэх боломж бүхий үржил шимтэй хөрстэй
- Байгалийн үндсэн болон дагалдах баялагтай /жимс жимсгэнэ, ан амьтан-биологийн төрөл зүйлүүд/

3.Дэд бүтцийн хувьд

- Гадаад харилцаа хөгжүүлэх таатай боломж бүрдсэн /Монгол-Оросын хилийн боомт, Алтанбулаг олон улсын худалдааны чөлөөт бус/
- Зам харилцаа /ОХУ – Монгол Улс – БНХАУ-ыг холбосон төмөр зам, автозам/
- Мэдээлэл, харилцаа холбоо сайн хөгжсөн

Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд анхаарах асуудлууд:

1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрөл цөөн
2. Жуулчин хүлээн авах хүчин чадал бага
3. Мэргэжлийн ажиллах хүчиний нөөц хомс

4. Гадаад, дотоод жуулчдыг татахад чиглэсэн маркетинг, сурталчилгааны ажил хангалттай биш
5. Үйлчилгээний стандарт сайжруулах шаардлагатай
6. Сэдэвчилсэн аялалын маршрут одоогоор хийгдээгүй

Нэг.Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөр

1.1.Хөтөлбөрийн зорилго

Сэлэнгэ аймгийн байгалийн нөөцийүүд, түүх, соёлын дурсгалт зүйлийг зохистой ашиглах, хамгаалах, сурталчлах замаар орон нутгийн онцлогт тохируулан аялал жуулчлалын тогтвортой хөгжлийг хангахад уг хөтөлбөрийн зорилго оршино.

1.2.Хөтөлбөрийн зорилт

1.2.1.Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн үйлчилгээний нөхцөл, үйл ажиллагааг стандарт, шаардлагад нийцүүлэх;

1.2.2.Аялал жуулчлалын төрлүүдийг шинээр бий болгон хөгжүүлэх;

1.2.3.Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх;

1.2.4.Аялал жуулчлалын хүний нөөцийг сургах, мэргэшүүлэх;

1.2.5.Жуулчдад зориулсан мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагаа, сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх;

1.3.Хөтөлбөр хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг баримтлана. Үүнд:

1.3.1.Аялал жуулчлалын үйл ажиллагааг байгалийн унаган төрхийг хадгалах, орчныг бохирдуулахгүй байх, экологийн тэнцвэрт байдал, эрүүл, аюулгүй орчинд аялах нөхцлийг хангах, орон нутгийн иргэдийн амьдрах орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхаар зохион байгуулах;

1.3.2.Төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаанд тулгуурлах, иргэд, олон нийтийн оролцоог дэмжих, салбар дундын болон төр, орон нутгийн байгууллагын үйл ажиллагааны уялдааг хангах;

Хоёр.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн санаачлага, идэвх оролцоог дэмжиж татан оролцуулна.

Гурав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат

Хөтөлбөрийг дараах үе шаттайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

Нэгдүгээр үе шат: 2017-2020он

Жуулчид хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлж, аймгийн хэмжээнд аялал жуулчлал хөгжүүлэх боломжийг сурталчлах, байгалийн үзэсгэлэнт болон түүх, соёлын дурсгалт газруудыг үндэсний аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд хамруулж , иргэдийн бизнесийг дэмжсэн, амжиргааг дээшлүүлэх нөхцлийг бүрдүүлэх;

Хоёрдугаар үе шат:2021-2024он

Бүсийн төвүүдэд аялал жуулчлалын төвүүдийг бий болгож, аялагч, жуулчдын сонирхлыг татсан аяллын шинэ төрлүүдийг хөгжүүлж, бүтээгдэхүүн, үйлчилгээг Олон улсын түвшинд хүргэн, аялал жуулчлалаас олох ашиг орлогыг нэмэгдүүлж, эдийн засагт оруулах хувь нэмрийг өсгөх;

Дөрөв.Үйл ажиллагаа

4.1.Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн үйлчилгээний нөхцөл, үйл ажиллагааг стандарт, шаардлагад нийцуулэх;

4.1.1.Аялал жуулчлалын салбарт цогц судалгаа хийх;

-Аялал жуулчлалын үзэсгэлэнт газар, түүх дурсгалын газар, үйл ажиллагаа эрхлэгчдийн цогц судалгааг хийж мэдээллийн санг баяжуулах;

-Өөрийн улсын болон гадаад улсын аялал жуулчлалын салбарыг судалж, туршлага нэвтрүүлэх;

-Жуулчны бааз, тур опературуудтай хамтран ажиллаж жуулчид аялагчдын сэтгэл ханамжийн судалгаа авч үйл ажиллагаа, үйлчилгээг сайжруулж ажиллах;

4.1.2.Аялагч, жуулчдын ихээр цуглардаг газрууд, жуулчны бааз, амралтын газруудын цэвэр бохир ус, био 00, агааржуулалтын систем зэргийг стандарт шаардлагын дагуу шийдэх;

-Жуулчны бааз, амралтын газруудын цэвэр бохир ус, био 00, агааржуулалтын систем зэргийг стандарт шаардлагад нийцсэн болгох;

-Түүх дурсгалын газар, цэцэрлэгт хүрээлэн, цогцолбор газар, аялагч, жуулчид ихээр цуглардаг байгалийн үзэсгэлэнт газруудын био 00-н асуудлыг шийдвэрлэх;

-Хог хаягдлын менежментийг сайжруулж түүх дурсгалын газар, байгалийн үзэсгэлэнт газарт хог хаягдалгүй эко орчинг бүрдүүлнэ.

4.1.3.Жуулчны бааз, амралтын газруудыг аттестатчилж, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог болох;

-2 жилд нэг удаа аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран нөхөрсөг зөвлөгөө өгч дэмжиж ажиллана

-Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, жуулчны бааз, амралтын газруудад зөвшөөрөл олгох журам боловсруулж хэрэгжүүлж ажиллах;

-2 жилд нэг удаа аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдэд мэргэжлийн байгууллагуудтай хамтран аттестатчилал явуулах;

4.2. Аялал жуулчлалын төрлүүдийг шинээр бий болгон хөгжүүлэх;

4.2.1.Сэлэнгэ аймагт хөгжүүлэх боломжтой аялал жуулчлалын төрлүүдийг тодорхойлох, төлөвлөгөө боловсруулах;

-Сэлэнгэ аймагт хөгжүүлэх боломжтой аялал жуулчлалын төрлүүдийг судалгаанд үндэслэн тодорхойлох;

- Тодорхойлогдсон аялал жуулчлалын төрлүүдийг хөгжүүлэх төлөвлөгөөг жил бүр гаргаж хэрэгжүүлж ажиллах;

-Орон нутгийн онцлогт нийцсэн эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах /Үүнд: “Эв модны наадам”, “Бумбын тахилга”, “Алтан намар”, “Хаврын баяр-Ханш нээх”/

4.2.2.Сэлэнгэ аймагт аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүдийн аялал жуулчлалын төрлийг нэмэгдүүлэх шинэ санал, шинэлэг төсөл, бизнесийн үйл ажиллагааг дэмжих;

-Олон улсын төсөл, хөтөлбөрүүдтэй хамтран санхүүгийн дэмжлэг үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх;

-Мэргэжлийн байгууллагуудтай хамтран сургалт, зөвлөгөөн зохион байгуулах;

4.3. Аялал жуулчлалын салбарын дэд бүтцийг сайжруулж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх;

4.3.1. Аялал жуулчлалын гол чиглэл болж тодорхойлогдсон маршрутын дагуу дэд бүтцийг хөгжүүлэх;

-Жуулчны бааз, амралтын газрууд хооронд маршрутын дагуу дэд бүтцийг хөгжүүлэх

4.3.2. Аялал жуулчлалын гол чиглэл болж тодорхойлогдсон маршрутын дагуу түр буудаллах цэгүүдийг бий болгон үйлчилгээ үзүүлэх;

-Түр буудаллах цэгүүдэд амрах хэсэг байгуулж, стандартын дагуу тохижуулах;

4.3.3. Аялал жуулчлалын томоохон цогцолборуудыг байгуулж хөгжүүлэх;

-“Сүхбаатар самбар”-ыг аялагч жуулчдыг хүлээн авах, үдэх цогцолбор болгож тохижуулах;

-Аймгийн төвийн ойролцоо “Сэлэнгэ түмний хийморь” аялал жуулчлалын цогцолбор байгуулах;

-Алтанбулаг сумын “Гүн нуур” орчмыг тусгай хамгаалалтанд авч аялал жуулчлалын цогцолбор байгуулах;

4.3.4. Аялал жуулчлалын нэгдсэн маршрут зэрэг холбогдох мэдээлэл бүхий самбар, таних тэмдэг байршуулах;

-Амрах газрууд, замын уулзвар хэсгүүдэд таних тэмдэг, самбар байрлуулах;

4.4. Аялал жуулчлалын хүний нөөцийг сургах, мэргэшүүлэх;

4.4.1. Туршлага солилцох уулзалт, сургалт тогтмол зохион байгуулах;

-Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа жуулчны бааз, амралтын газрууд хооронд урт хугацааны уралдаан зарлах;

4.4.2. Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийн боловсон хүчинийг сургах, мэргэшүүлэх;

-Аялал жуулчлалын тайлбарлагч хөтөч бэлдэх;

-Аялал жуулчлалын салбарт хэрэгцээт сургалтыг тодорхойлж сургалт явуулж байх;

4.4.3. Мэргэжлийн үнэмлэх, гэрчилгээ олгох эрх бүхий сургалтын төв, хөдөлмөр зуучлалын төвтэй болох;

-Хөдөлмөр зуучлалын салбар төв байгуулж ажлын үнэмлэх олгох эрх бүхий сургалтын үйлчилгээ явуулж, салбартай мэргэшсэн боловсон хүчинээр хөдөлмөрийн зуучлалын үйлчилгээ үзүүлдэг болох;

4.5. Жуулчдад зориулсан мэдээллийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хамтын ажиллагаа, маркетинг сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх;

4.5.1. Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын маршрутыг тодорхойлж олон нийтэд таниулан суртачлах;

-Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын маршрут, танилцуулга бүхий газрын зураг, тараах материал гаргаж олон нийтэд түгээх;

-Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын маршрут танилцуулга бүхий ухаалаг утасны апликэйшнтай болох;

4.5.2. Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын холбоо, жижиг дунд үйлдвэрлэгчдийн холбоо зэрэг төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж хоорондын уялдаа холбоог сайжруулж хамтын ажиллагааг өргөтгөх;

-Сэлэнгэ аймгийн аялал жуулчлалын холбооны үйл ажиллагааг дэмжиж ITM зэрэг аялал жуулчлалын үзэсгэлэнд тогтмол оролцох;

-Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчид хооронд уулзалт зөвлөгөөн тогтмол хийх

4.5.3. Аялал жуулчлалын салбарын бусад салбар хоорондын уялдаа холбоог сайжруулах;

-Аялал жуулчлалыг хөгжүүлэх зөвлөлийг шинэчилж үйл ажиллагааг эрчимжүүлэх

-Нийтийн тээврийн “Зэлтрийн зам” ХХК-ийг аялал жуулчлалын оператор компани болоход дэмжиж ажиллах;

-Зочид буудал, зоогийн газар, соёлын төв болон жуулчны бааз, амралтын газар хоорондын уялдаа холбоог сайжруулж аялал жуулчлалыг сурталчлах зураг, брошюр байрлуулах

-Соёлын төвүүдтэй хамтран жуулчдад зориулсан урлаг соёлын үзүүлбэртэй болох;

-Сэлэнгэ аймгийн нэгдсэн музейг аялал жуулчлалын маршрутанд тусгах;

4.5.4. Аялал жуулчлалын орон нутгийн онцлог бүтээгдэхүүн /бэлэг дурсгалын зүйл/, үйлчилгээг бий болгох;

-Аймаг орон нутгийн онцлогийг харуулсан бэлэг дурсгалын бүтээгдэхүүний шинэ санаа гаргах уралдаан зарлаж шалгарсан бүтээлд зээлжилт олгон үйлдвэрлэлийг эхлүүлэх;

-Аймаг орон нутгийн онцлогийг харуулсан бэлэг дурсгалын бүтээгдэхүүн үйлдвэрлэх аж ахуй нэгж, иргэдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

4.5.5. Байгалийн үзэсгэлэнт газрыг хамгаалах;

-Сэлэнгэ аймгийн 9 бахархалыг тодруулж нийтэд суртачлах;

-Тодруулсан Сэлэнгэ аймгийн 9 бахархал болсон түүхт болон байгалийн үзэсгэлэнт газруудыг хамгаалалтанд авах;

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ.

А. Орон нутгийн төсөв

Б. Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгө

В. Олон улсын зээл, тусlamж, хандивын хөрөнгө

Г. Төсөл хөтөлбөрийн санхүүжилт

Д. Бусад эх үүсвэр

Зургаа.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

Аялал жуулчлалыг хөгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Орон нутаг дахь хөрөнгө оруулалт нэмэгдэнэ.
- Ажлын байр шинээр бий болж ажилгүйдлийг багасгана.
- Жижиг дунд үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаа сайжирч, иргэдийн амьжиргааны түвшин дээшлэнэ.
- Дэд бүтэц хөгжинө.
- Үйлчилгээний шинэ төрлүүд нэмэгдэж, үйлчилгээний чанар сайжирна
- Тухайн нутгийн түүх, ёс заншил, соёлын үнэт дурсгалт зүйлсээр бахархах, түүнийг хайрлах сэтгэлийг иргэд, хүүхэд багачуудад нэмэгдүүлнэ.
- Олон Улсын соёл нэвтэрч харилцан суралцах боломжтой болно.

- Аялал жуулчлалаас олсон орлогоор түүх, соёлын дурсгалт зүйлсийг сэргээн босгох, байгаль орчин, ан амьтанаа хамгаалах, нөхөн сэргээх санхүүгийн боломжтой болж эдийн засгийн бие даасан салбар болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН ХЭЛТЭС